



**ХЭНТИЙ АЙМАГ
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 23 өдөр

Дугаар A/197

Өмнөдэлгэр сум

**Мотоцикл, мопедийн хөдөлгөөн түр
хугацаагаар хориглох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зорчих хэсгийн гадаргуу цасаар хучигдан халтиргаа гулгаа үүсч, тээврийн хэрэгслийн зорчих хэсгийн нөхцөл байдал хүндэрсэн үед мотоциклоор замын хөдөлгөөнд оролцогчдын эрүүл мэнд, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, учирч болох хор хохирол эрсдэлийг багасгах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах зорилгоор сумын нутаг дэвсгэрт мотоциклтой замын хөдөлгөөнд оролцохыг 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрөөс 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл түр хугацаагаар хязгаарласугай.

2. Ард иргэдэд хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай анхааруулга, сэрэмжлүүлэг өгөн, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг сумын хэсгийн төлөөлөгч, ахлах дэслэгч Б.Тэмүүжин, багийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, цаашид авах арга хэмжээний саналыг танилцуулж байхыг Засаг даргын орлогч (Э.Заяабаяр)-д даалгасугай.



Б.ЭРДЭНЭБААТАР

D:\disk\bichig hereg/ zahiramj

2024100406